



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/681

Өлгий


**Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах, шинээр олгох, нэмэлт
өөрчлөлт хийх тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.18 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хугацаа сунгуулсан, эрх шинээр олгосон, тусгай зөвшөөрлийн чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулсан, чиглэл өөрчилсөн, эрхлэгчээ сольсон эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хууль, эмийн сангийн стандарт болон үйл ажиллагаанд холбогдох бусад хууль, журмыг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг сунгуулж буй хувийн ортой эмнэлгүүд, үүдэн эмнэлгүүд, эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрлийн комисс (К.Бижан), Мэргэжлийн хяналтын газар /Б.Мухамет/, Эрүүл мэндийн газар (С.Айгүл) нарт тус тус үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын 2018 оны 11 тоот
захирамжийн хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	Гэрчилгээний дугаар	Сунгалт	Дуусах хугацаа
1	Ушкын эмийн сан	АҮХ-15/02/22	5 жилээр	2023.08.17
2	Өлгий ариутгал	ЭСХ-11/02/08	5 жилээр	2023.07.09
3	Шамшырах нүдний эмнэлэг	ЭХ-10/02/07	5 жилээр	2023.07.31
4	Бейс-Шипа ортой эмнэлэг	ЭХ-10/02/08	5 жилээр	2023.08.31

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх шинээр олгосон байгууллагууд

№	Байгууллагын нэр	Зөвшөөрөл олгосон он, сар, өдөр	Зөвшөөрлийн хугацаа	Хүчинтэй хугацаа
1	“Ахихат айнасы” ХХК, Астма эмнэлэг	2018.07.30	3 жилээр	2021.07.30
2	“Еркөкше” ХХК, Энэрэл эмийн сан	2018.07.30	3 жилээр	2021.07.30
3	“Элиф” ХХК, Элиф эмийн сан	2018.07.30	3 жилээр	2021.07.30

Тусгай зөвшөөрлийн чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулсан, чиглэл өөрчилсөн, эрхлэгчээ сольсон байгууллагууд

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагаа явуулах чиглэл	Нэмэлт өөрчлөлт
1	Наз дарумен ХХК	Эмийн сан	Эрхлэгчээ солих /Б.Наранцэцэг/
2	Бейс-Шипа ХХК	Дотор, мэс заслын эмч	Хүүхдийн мэс засал
3	Шегиртай	Сувилал	Амралт, сэргээн засах сувилал
4	Сансар	Эмнэлэг	Дотор, мэдрэл, уламжлалт